ХАН-УУЛ ЭРҮҮЛ МЭНДИЙН ТӨВ

# ХАН-УУЛ ЭРҮҮЛ МЭНДИЙН ТӨВИЙН ХӨГЖЛИЙН ДУНД ХУГАЦААНЫ СТРАТЕГИ ТӨЛӨВЛӨГӨӨ 2018-2020 ОН

Улаанбаатар хот

2017 он

БАТЛАВ

ХАН-УУЛ ЭРҮҮЛ МЭНДИЙН ТӨВИЙН ДАРГА Э.БОДЬЦЭЦЭГ

2017 оны 12 сар 25 өдөр

ТТБ2350 9120262

# ХАН-УУЛ ЭРҮҮЛ МЭНДИЙН ТӨВИЙН ХӨГЖЛИЙН ДУНД ХУГАЦААНЫ СТРАТЕГИ ТӨЛӨВЛӨГӨӨ 2018-2020 ОН

ТӨЛӨВЛӨГӨӨГ БОЛОВСРУУЛСАН:

СТРАТЕГИ БОДЛОГО ТӨЛӨВЛӨЛТ ЭРХЭЛСЭН ОРЛОГЧ ДАРГА

Ц.ТУЛГА

Дотоод орчны шинжилгээ

| Давуу тал | Сул тал |
|---|---|
| **Удирдлага, зохион байгуулалт** | |
| - ЭМЯ, НЭМГ, дүүргийн ЗДТГ, Нийгмийн эрүүл мэндийн үндэсний төв, Эрүүл мэндийн хөгжлийн төвөөс зөвлөмж, дэмжлэгээр хангадаг;<br>- Байгууллагын зорилго, үйл ажиллагааг дүрмээр зохицуулж өгсөн;<br>- Байгууллагын удирдах зөвлөл 9 гишүүнтэйгээр явуулдаг;<br>- Эрүүл мэндийн тусламж үйлчилгээг поликлиник, салбар амбулатори, ӨЭМТ-үүд, нарийн мэргэжлийн кабинетууд болон нийгмийн эрүүл мэндийн алба, эмнэлгийн тусламж үйлчилгээний алба, чанарын алба, сувилахуйн алба, захиргаа, санхүү, хяналт шинжилгээ, мэдээлэл технологийн алба гэсэн бүтэцтэй үйл ажиллагаа явуулдаг;<br>- Байгууллагад ёс зүйн хороо, үйлдвэрчний эвлэлийн хороо тогтмол ажилладаг;<br>- Ажилтан бүртэй ажлын байрны тодорхойлолт, хөдөлмөрийн гэрээг байгуулдаг;<br>- Удирдлагын зүгээс эмч, ажилчдыг урамшуулахад анхаарал  тавьж ажилладаг;<br>- Байгууллагын дотоод сүлжээ, цахим сүлжээнд холбогдсон бөгөөд тусламж үйлчилгээний програмуудыг үйл ажиллагаандаа  ашигладаг; | - Дээд шатны байгууллагуудтай нягт уялдаа холбоотой байж, асуудлыг шийдвэрлэдэггүй байсан;<br>- Байгууллагын бүтэц зохион байгуулалтыг зорилго, стратегид нийцүүлээгүй, байгуулагын стратеги төлөвлөгөөгүй байсан;<br>- Удирдах зөвлөлийн хурал багийн зарчмаар ажилладаггүй байсан;<br>- Төлөвлөлт, хяналт-шинжилгээ, үнэлгээний нэгж албадуудын  байнгын ажиллагаа хангалтгүй . Ажиллагсад энэ талын мэдээлэл дутмаг;<br>- Алба, нэгжүүдийн үйл ажиллагаа тодорхой хэдий ч мэргэжилтэн бүрт ажлыг зөв хуваарилаагүйгээс ажил орхигдсон, мэргэжилтэн бүрийн ачаалал их бага зэрэг ялгаатай байна;<br>- Байгууллагын ил тод байдал хангалтгүй, цахим хуудас байнгын ажиллагаагүй байв;<br>- Ажлын байрны тодорхойлолт, хөдөлмөрийн гэрээнд хариуцлагатай холбоотой заалтууд нарийвчилж оруулаагүй; |
| **Дотоод дүрэм журам** | |
| - Байгууллагын дотоод журмыг батлан мөрдүүлж байна;<br>- Үйл ажиллагаа явуулах дүрэм, журам, эрх зүйн орчин тодорхой хэмжээгээр бүрэлдсэн;<br>- Ажиллагсдыг улирал бүр гүйцэтгэлийн үнэлгээгээр үнэлж, урамшуулдаг; | - Тушаал шийдвэрийн хэрэгжилтийг хангах ажиллахад ажилчдын идэвх санаачлага сул;<br>- Аливаа үйл ажиллагаа дүрэм журамд баригддаг тул өөрчлөлт хийх, хүлээн авах сонирхол, хүсэл эрмэлзэл бага;<br>- Хяналтын системийг сайжруулах, үр дүнг үнэлэх системийг боловсронгуй болгох; |
| **Хүний нөөц** | |

| | |
|---|---|
| - Эмч нарын 31 % нь мэргэжлийн зэрэгтэй, сувилагч нарын 29 % нь мэргэжлийн зэрэгтэй, сувилагч нарын 29 хувь боловсролын бакалавр зэрэгтэй,1 эмч клиникийн профессор цолтой, 0 эмч анагаах ухааны доктор цолтой өндөр мэдлэг, туршлага, ур чадвар бүхий эмч, эмнэлгийн ажиллагсадтай;<br>- Хүний нөөцийн нөхөн хангалт тухай бүр хийгдэж, мэргэжлийн боловсон хүчнээр хангагдсан;<br>- Удирдлагын зүгээс ажиллагсдаа хөгжүүлэх, мэргэшүүлэх чиглэлээр гадаад дотоодын сургалт, уулзалт, семинарт хамруулдаг;<br>- Хүний нөөцийн хэрэгцээг тодорхойлж, бодлогыг боловсруулсан;<br>- Эмч, мэргэжилтэн мэргэжил олгох сургалтанд бүрэн хамрагдсан;<br>- Эмч, эмнэлгийн мэргэжилтэн 100% эмчлэх, эм барих, сувилах мэргэжлийн үйл ажиллагаа явуулах зөвшөөрөлтэй;<br>- Багц цагийн биелэлт эмч 97.%, сувилагч 95% байдаг; | - Өндөр боловсролтой, мэдлэг чадвартай боловсон хүчин шинээр ажилд орох магадлал бага;<br>- Сургаж, мэргэшүүлсэн боловсон хүчнээ тогтвор суурьшилтай ажиллуулж чадахгүй байх;<br>- Албан хаагчдын мэргэжлийн мэдлэг, ур чадвар, идэвх санаачилга, өөрчлөлт хийх хүсэл эрмэлзэл хангалтгүй;<br>- Эрүүл мэндийн сайдын ..... тоот тушаалаар баталсан орон тоо нь үзүүлж буй тусламж үйлчилгээний эрэлттэй харьцуулахад хүрэлцдэггүй;<br>- Байгууллагын эмч, эмнэлгийн ажилтан нар судалгаа шинжилгээний бүтээл байнга хийдэггүй;<br>- Гадаадын сургалт, семинарт ажиллагсдыг хангалттай хэмжээгээр хамруулахад англи хэл, санхүүгийн бэрхшээл учирдаг; |
| **Техник, технологи** | |
| - Үйл ажиллагаа хэвийн явуулах техник, тоног төхөөрөмжөөр хангагдсан;<br>- Техник, технологийн ашиглалт, судалгаа, шинжилгээ хийдэг;<br>- Төсөл хөтөлбөрийн шугамаар дэвшилтэд техник, технологиор хангагддаг; | - Актлах шаардлагатай техник, тоног төхөөрөмжинд байнга эвдрэл гардаг;<br>- Нөхөн хангалт хийгдэх боломж хязгаардмал;<br>- Төсвөөс шалтгаалан шаардлагатай техник, тоног төхөөрөмж, багаж худалдан авч чаддаггүй; |
| **Ажлын байрны нөхцөл** | |
| - Ажлын байрны байршил сайтай;<br>- Ажлын байрны шаардлагатай техник, тоног төхөөрөмжөөр зохих түвшинд хангагдсан;<br>- Албан хаагчдын нийгмийн асуудлыг шийдвэрлэх, эрүүл мэндийг хамгаалах хөтөлбөр хэрэгжиж байгаа;<br>- Ажлын байрны тохижилт тодорхой хэмжээнд хийгддэг; | - Шаардлагатай өрөө хүрэлцэхгүй, хэрэгцээ хангагдахгүй;<br>- Барилгууд ашиглалтын хугацаа хэтэрсэн, эвдэрч муудсан, стандартын шаардлага хангахгүй;<br>- Төсөв, санхүүгийн нөхцлөөс шалтгаалж, албан хаагчдын нийгмийн баталгаа хангагдахгүй байх;<br>- Засвар, тохижилтын ажилд санхүүжилт хүрэлцдэггүй; |
| **Санхүү, төсөв** | |

Хан-Уул эрүүл мэндийн төв

| | |
|---|---|
| - Хөрөнгө, санхүүгийн эх үүсвэр тогтвортой, төсвөөс болон НД-ын сангаас санхүүждэг;<br>- Өр, авлагагүй ажилладаг;<br>- Олон улсын байгууллагын төсөл, хөтөлбөрийн шугамаар нэмэлт санхүүжилт шийдэгдэх боломжтой;<br>- Санхүү, нягтлан бодох бүртгэлийн нийт ажилтнууд тухайн мэргэжлээрээ дээд боловсрол эзэмшсэн; | - Жилийн төсөв бодит хэрэгцээнд хүрэлцдэггүй;<br>- Сүүлийн жилүүдэд олон улсын төсөл санхүүжүүлэгч байгууллагуудын тоо багасч байгаа тул төсөл хэрэгжүүлэхэд хүндрэл учирдаг; |
| Үйлчилгээ | |
| - Тэмдэглэлт өдрүүдээр өдөрлөг, аян зохион байгуулдаг;<br>- Угтах үйлчилгээ  хэрэгжиж байгаа;<br>- Үйлчилгээ авах баримт бичгийн бүрдүүлэлтийг жагсаалтыг гаргаж байршуулсан;<br>- Үйлчлүүлэгчдийн өргөдөл, гомдлыг хүлээн авах, шийдвэрлэх, хариу өгөх үйлчилгээ нээлттэй явагддаг; | - Гаднах талбайн хүртээмж багатайгаас үйлчлүүлэгчдийн автомашины зогсоол хүрэлцдэггүй;<br>- Галын болон гамшгийн төлөвлөгөөний дагуу зохион байгуулах арга хэмжээнд төсөв хөрөнгө бага;<br>- Хүн амын эрүүл мэндийн боловсрол харилцан адилгүй байдаг нь тусламж, үйлчилгээнд сөргөөр нөлөөлдөг; |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| 32 | Эрүүл мэндийн төвд хөтлөгдөх анхан шатны шинэчлэгдсэн бүртгэлийн маягт, үзүүлэлт тооцох аргачлалыг хэрэгжүүлж хэвшүүлэх | | | | | Батлуулсан эрх зүйн акт | Эмнэлэгт хөтлөгдөх бүртгэл, мэдээлэлийн тоон үзүүлэлт бодит болно. | ЧА |
| | ***Гурав. Байгууллага удирлага хөгжлийн хүрээнд*** | | | | | | | |
| 1 | Эмч, эмнэлгийн мэргэжилтнийг мэргэжил боловсролоо дээшлүүлэхэд дэмжлэг үзүүлж, хүний нөөцийг чадваржуулна. | Байгууллагын удирдлага, эмч эмнэлгийн мэргэжилтнүүдийг удирдлага зохион байгуулалт, ур чадварын чиглэлээр Ур чадварын хүрээлэн ТББ, Монголын Хүний нөөцийн институтэд сургалт зохион байгуулна. | | | | Сургалтын тоо, хамрагдалтын тоо | Эмч эмнэлэгийн ажилчдын мэдлэг ур чадвар нэмэгдэнэ. | ХНА |
| | | Эмч, эмнэлгийн мэргэжилтний англи хэлний мэдлэгийг ахиулах сургалт зохион байгуулна. | | | | Сургалтын тоо, хамрагдалтын тоо | | |
| 2 | Мэргэжлийн тусламж үйлчилгэний шинэ технологи туршлага, сувилагчдын ур чадварыг хөгжүүлэх дэмжих ном сурах бичгээ албаны дэргэд номын сангийн эх үүсвэр бий болгох. | | | | | Номын сантай болж уншигчийн карт хөтөлдөг болно. | Сувилахын алба дэргэдээ номын фонтой болсон мэргэжилтнүүд хэрэгцээт номоо уншиж судалдаг болсоноор сувилагчдын онол, ур чадварыг хөгжүүлэхэд дэмжлэг болно. | СА |
| 3 | Эрүүл мэндийн төвийн удирдлага, эмч, эмнэлгийн ажилчдыг тусламж, үйлчилгээний чанар, аюулгүй байдал, эрсдлийн менежмент, алдаанаас суралцах чиглэлээр сургах сургалт зохион байгуулах | | | | | Сургалтанд хамрагдсан ажилтны тоо,<br>шинээр нэвтрүүлсэн үйл ажиллагааны тоо | Чанар тусламж үйлчилгээг сайжруулах арга хэрэгсэлийг шинээр үйл ажиллагаандаа нэвтрүүлсэн байна. | ЧА |
| 4 | Эмнэлгийн мэргэжлийн алдаа, доголдлыг үнэн зөв бүртгэж, урьдчилан сэргийлэх, эмнэлгийн тусламж, үйлчилгээний чанар, аюулгүй байдлын хяналтын тогтолцоог сайжруулан, ажиллах | | | | | Шинээр нэвтрүүлсэн шалгуур үзүүлэлтийг тоо | Бүртгэгдсэн гадаад алдаанд дүн шинжилгээ хийж, алдаанаас суралцах хэлэлцүүлэг хийсэн байна. | ЧА |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 5 | Байгууллагын ил тод байдлыг хангах талаар хэрэгжүүлсэн үйл ажиллагаанд хяналт тавьж ажиллах | | | | Мэдээлэлийн тоо, ил тод байдлын самбрын мэдээллийн тоо | Хэрэглэгчдийг шинэ мэдээ, мэдээллээр шуурхай хангана. | ДХ |
| 6 | Хууль тогтоомж, тогтоол шийдвэр, бодлогын баримт бичгийн биелэлт болон авилгатай тэмцэх үндэсний хөтөлбөрийн хүрээнд хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөнд хяналт тавьж ажиллан байгууллагад сурталчилах хэрэгжүүлэх талаар сургалт зохион байгуулах, | | | | Авлигаас урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх чиглэлийн мэдээлэл, сургалтын тоо, сургалтанд хамрагдсан хүний тоо, | Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн биелэлт сайжирч мэдлэг дээшилнэ Авлигын эсрэг хууль, тогтоомжийн хэрэгжилт хангагдана. Авлига, албан бус төлбөртэй холбоотой зөрчил дутагдал арилна. | ДХ |
| 7 | Эрүүл мэндийн төвийн эмч, эмнэлгийн мэргэжилтэнд зориулсан ёс зүй, харилцаа хандлагын сургалтыг зохион байгуулна. | | | | Сургалтын тоо | Эмч, эмнэлгийн мэргэжилтний ёс зүй, харилцаа хандлага сайжирсан байна. | ХНА |
| 8 | Эрүүл мэндийн төвийн статистикийн тайлан мэдээ гаргаж, дүгнэлт хийн арга хэмжээ авч ажиллана. | | | | Боловсруулан гаргасан тайлан мэдээ | Төвийн үйл ажиллагаа сайжирна | СМА |
| 9 | Эмч, эмнэлгийн мэргэжилтний эрдмийн уулзалтыг зохион байгуулна. | | | | Хамрагдсан хүний тоо | Эмч, эмнэлгийн мэргэжилтний мэдлэг, ур чадвар дээшлэнэ. | ЭЭО |
| 10 | Байгууллагын ажилчдын ажлын гүйцэтгэлийг үр дүнгээр тооцон сайжруулах ажлыг зохион байгуулах. | | | | Урамшуулал авсан ажилтны тоо | Гүйцэтгэлийн үр дүнг тооцож, урамшуулсан байна. | ЗАА |
| 11 | Эмнэлгийн мэргэжилтний төгсөлтийн дараах мэргэшүүлэх болон мэргэжил дээшлүүлэх сургалтанд эмч эмнэлгийн мэргэжилтнүүдийг хамруулах /Хими эмчилгээ, гемодиализ, яаралтай тусламж/ | | | | Эмч мэргэжилтний тоо | Хүний нөөцийн чадавхи сайжирна. | ЭМТ |
| 12 | Байгууллагын бүтэц зохион байгуулалтыг сайжруулж, орон тоог төсөвт уялдуулан оновчтой зохион байгуулах | | | | Байгууллагын тушаал шийдвэр | Батлагдсан бүтэц, орон тооны эрх зүйн бичиг баримт. | ХНМ, СА |
| 13 | Байгууллагын хөтлөх хэргийн нэрийн жагсаалтыг шинэчлэн батлуулах,архивлан төрийн архивт нөхөн бүрдүүлэлт хийх, холбогдох тайлан мэдээ гаргах | | | | Тайлан, мэдээ | Хөтлөх хэргийн жагсаалтын дагуу архивлагдсан байна. | АБХА |
| 14 | Хүний нөөцийн хөгжлийн хөтөлбөрийг шинэчлэн боловсруулж, хэрэгжүүлэх, эмч, эмнэлгийн | | | | Сэлгэн ажилсан, эмчийн тоо, тайлан | Хүний нөөцийг хөгжүүлэх үйл ажиллагааны | УБ,ХНМ |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | мэргэжилтнийг төрөлжсөн мэргэжлийн эмнэлгүүдэд сэлгэн ажиллуулах гэрээ байгуулж, хэрэгжүүлэх | | | | | нэгдсэн бодлоготой болно. | |
| 15 | Ёс зүйн хэсгийн хорооны төлөвлөгөөг боловсруулж,хэрэгжүүлэн, үр дүнг тооцон ажиллаж, сургалтандп үе шаттай хамруулах | | | | Төлөвлөгөө, сургалт | Төлөвлөгөөний биелэлтийн хувь. | ЁЗСХ,ХНМ |
| 16 | Эмнэлгийн ажилтны өдрийг тохиолдуулан "Инээмсэглэн угтаж, итгэл төрүүлэн үдье" ажлаа сурталчилах, эмч, ажилчдын хөдөлмөр алдар тэмдэглэх өдөрлөг зохион байгуулах. | | | | Ажлын тайлан | Удирдамж, тайлан. | ХНМ |
| 17 | Байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд аудитын шалгалтаар илэрсэн зөрчил, зөвлөмжийг хэрэгжүүлэн, үр дүнг тооцох. | | | | Байгууллагын тушаал шийдвэр, тайлан | Санхүүгийн үйл ажиллагаа сайжирна. | СА |
| 18 | Байгууллагын санхүү, хөрөнгө, бараа материалын зарцуулалтанд дэмжлэгт хяналт хийж, үр дүнг тооцох. | | | | Хяналтын тоо | Санхүүгийн эрсдлээс хамгаална. | ДХ, ЭЗ |
| 19 | Төсөв санхүүгийн стастистикийн эмхэтгэл бэлтгэх. | | | | Эмхтгэлийн тоо | Санхүүгийн мэдээллийн сан үүснэ. | ЭЗ |
| 20 | ХУДЭМТ-ийн сүүлийн 5-10 жилийн эрүүл мэндийн үндсэн үзүүлэлтийг эмхэтгэн ном гаргах. | | | | Эмхтгэл номын тоо | Эмхэтгэл гарган, дүгнэлт хийсэн байна. | СА |
| 21 | Хэвтэн эмчлүүлэх тасаг,яаралтай тусламж ,эрчимт эмчилгээний тасагт засвар үйлчилгээ хийж, урсгал зохион байгуулалтыг сайжруулах. | | | | Засвар үйлчилгээ | Эмнэлгийн тусламж үйлчилгээний чанар, хүртээмж сайжирна. | ЗААА |
| 22 | Ариутгалын кабинетын их засвар хийж, үйлчилгээний чанар стандартыг сайжруулан, үйл ажиллагаанд хяналт тавьж, стандарт мөрдөлтийн хэрэгжилтийг ханган ажиллах. | | | | Засвар үйлчилгээ | Эмчилгээ үйлчилгээнд ээлтэй орчин бүрдэнэ. | ЗААА |
| 23 | Үйлчлүүлэгчдийн цахим мэдээллийн сан бүрдүүлэх, хөтлөх ажлуудад хяналт тавих, холбогдох програм хангамж, техник хангамжийн асуудлыг шийдвэрлэх, сайжруулах. | | | | Мэдээллийн сан, хяналтын тоо | Цахим бүртгэлийн үйл ажиллаагааны хэвийн байдал хангагдана. | МТМ |